

**ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 05 дугаар сарын 31-ний өдөр, Баасан гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-4
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	5-8
<i>1.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2026-2027 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл /Засгийн газар 2024.04.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	5
<i>2.Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд нарын 6 гишүүн 2024.05.17-ны өдөр өдөр мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	6-7
<i>3.Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа 2023.06.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	7-8

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Төрийн байгуулалтын байнгын хорооны
05 дугаар сарын 31-ний өдөр /Баасан гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Төрийн байгуулалтын байнгын хорооны дарга Н.Энхболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.6 хувийн ирцтэйгээр хуралдаан 09 цаг 48 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Ж.Батсуурь, С.Бямбацогт;
Чөлөөтэй: С.Амарсайхан, Ё.Баатарбилэг, Л.Оюун-Эрдэнэ;
Тасалсан: Т.Доржханд, М.Оюунчимэг.

Нэг.Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын Ерөнхийлөгч 2024.05.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ч.Батбямба, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн танилцуулгыг Байнгын хорооны дарга Н.Энхболд танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ж.Сүхбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 09 цаг 50 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд нарын 6 гишүүн 2024.05.17-ны өдөр өдөр мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Ч.Батбямба, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 1, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Н.Энхболд: 1.Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 32.13 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“32.13.Цахимаар хуралдаанд оролцсон бол санал хураахаас бусад асуудлаар Хурлын ирцэд оруулан тооцож болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 51.2 дахь хэсгийн “дараах асуудлаар шийдвэр гаргаж дараагийн хуралдаанд танилцуулж болно.” гэснийг “дараах асуудлыг хэлэлцэж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдаанд танилцуулж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 3
Бүгд: 11
72.7 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “32.10” дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

32.10.Баг, хорооны иргэдийн Нийтийн анхдугаар хуралдаанаас хуралдаан даргалагчийг 2 жилийн хугацаагаар сонгоно. Хуралдаан даргалагч нь хуралдааныг удирдан явуулах, хуралдааны шийдвэрийг албажуулан гарын үсэг зурах, дараагийн хуралдааны зохион байгуулалтын бэлтгэлийг хангах үүрэгтэй. Хуралдааны даргад баг, хорооны Засаг даргын албан тушаалын үндсэн цалингийн 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгож болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 4
Бүгд: 12

66.7 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 09 цаг 56 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Ш.Адъяаа 2023.06.23-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нямбаяр, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Төрийн байгуулалтын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Хатантуул, референт Э.Баттогтох, мөн хэлтсийн референт А.Наранцэцэг нар байлцав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Н.Энхболд: 1.Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Үндэсний их баяр наадмын тухай хуульд доор дурдсан агуулгатай 10.20 дахь хэсэг нэмсүгэй:

“10.20.Энэ хуулийн 10.19-д заасан жороо морины уралдаанд морио уяж, уралдуулсан уяачийн амжилт нь энэ хуулийн 10.4, 10.5, 10.6-д заасан болзлыг хангасан бол уяачид мөн хэсэгт заасан цол олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10

Татгалзсан: 2

Бүгд: 12

83.3 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболдын гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 3
Бүгд: 12
75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэж дуусав.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 09 цаг 59 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 11 минут үргэлжилж, ирвэл зохих 19 гишүүнээс 12 гишүүн хүрэлцэн ирж, 63.1 хувийн ирцтэйгээр 09 цаг 59 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Н.ЭНХБОЛД

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 05 дугаар сарын 31-ний өдөр,
Баасан гараг
Төрийн ордон “Жанжисин Д.Сүхбаатар”
танхим
09 цаг 48 минут.

ТӨРИЙН БАЙГУУЛАЛТЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Н.Энхболд: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе. Гишүүдийн олонх хүрэлцэн ирлээ, ирц бүрдсэн байна. Байнгын хорооны 2024 оны 5 сарын 31-ний өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье. Ирэх долоо хоногт манайх 2 удаа хуралдах байх. Тэгээд энэ бүрэн эрхийн хугацааны манай Байнгын хорооны ажиллагаа өндөрлөх тал руугаа орно. Идэвхтэй оролцохыг хүсье гишүүдийгээ дуустлаа. Хэлэлцэх асуудлаа танилцуулъя.

Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 24 оны 5 сарын 13-ны өдөр өргөн мэдүүлсэн хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийнэ.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Энэ төслийг Улсын Их Хурлын гишүүн Ганболд нарын 6 гишүүн 5 сарын 17-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг хийнэ.

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл. Энэ төслийг Их Хурлын гишүүн Адьшаа нарын 4 гишүүн 6 сарын 23-ны өдөр өргөн мэдүүлсэн. Төслийн анхны хэлэлцүүлгийг хийнэ.

Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүд байна уу?

Алга байна. Асуудалдаа орцгооё.

Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг явуулна.

Эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл, хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулга, тогтоолын төслөө.

Монгол Улсын Ерөнхийлөгчөөс 24 оны 5 сарын 13-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг Их Хурлын нэгдсэн чуулганаар 5 сарын 30-ны өдөр хэлэлцсэн. Ингээд эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд илгээжүүлсэн байсан.

Манай Байнгын хороо 5 сарын 31-ний өдрийн хуралдаанаараа чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42-т заасны дагуу Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн эцсийн хэлэлцүүлгийг явуулсан.

Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг тусгаж, бэлтгэсэн төсөл, Байнгын хорооны танилцуулгыг Их Хуралд оруулах ёстой. Хуулийн төслийг та бүхэнд тараасан байгаа.

Санал, асуулттай гишүүн байхгүй тээ? Байхгүй бол ингээд эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн танилцуулгыг сая хийчихлээ.

Асуулт байхгүй. Эцсийн хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Байнгын хорооны танилцуулгын чуулганы нэгдсэн хуралдаанд Сүхбаатар гишүүн хийнэ. Баярлалаа. Дараагийн асуудалдаа орёё.

09.50 цаг

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэх ёстой. Зүйл бүрээр нь явна.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйл дээр ажлын хэсгээс, би энийг авчихъя. 1 санал байгаа танилцуулъя.

Төслийн 1 дүгээр зүйлийн 32.13 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“32.13.Цахимаар хуралдаанд оролцсон бол санал хураахаас бусад асуудлаар Хурлын ирцэд оруулан тооцож болно.” гэсэн санал оруулж байна.

Ер нь бол цахимаар ирц бүрдүүлээд хуралдааныг эхэлж болно гэсэн агуулгатай заалт байсан. Цахимаар ирцэд орчхоод биеэр ирээгүй бол санал хураалтад яаж оролцох вэ гэдэг нь тодорхойгүй байсан учраас бид нар ийм тодруулалт хийх нь зүйтэй гэж бодсон. Энэ саналыг дэмжье гэсэн томъёоллоор, цахимаар хуралдаанд оролцсон бол санал хураахаас бусад асуудлаар Хурлын ирцэд оруулан тооцож болно гэсэн ийм томъёолол байгаа. Санал хураалт гишүүд ээ.

11 гишүүн оролцож, 8 нь дэмжиж, 72.7 хувиар санал дэмжигдлээ.

1 дүгээр зүйлийг хэлэлцэж дууслаа.

Төслийн 2 дугаар зүйл дээр санал, асуулт байхгүй байна.

3 дугаар зүйл дээр мөн санал гаргаж байна ажлын хэсгээс. Төслийн 3 дугаар зүйлийн 51.2 дахь хэсгийн “дараах

асуудлаар шийдвэр гаргаж дараагийн хуралдаанд танилцуулж болно.” гэснийг “дараах асуудлыг хэлэлцэж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралдаанд танилцуулж болно.” Энэ нөгөө зөвлөл хурлын өмнөөс шийдвэр гаргах заалт байсан. Тэр нь өөрөө Үндсэн хуулийн болоод бусад түрүүчийн батлагдсан хуулиудын үзэл баримтлалтай зөрчилдөөд өөрөөр хэлбэл, хурлын өмнөөс ямар нэгэн өөр бүтэц, шийдвэр гаргаж байж болохгүй гэсэн санааг агуулсан ийм зүйлтэй. Хуучин тэргүүлэгчид гэж байхад ингэж яваад байсан нь өөрөө Үндсэн хууль зөрчсөн, хурлын эрхийг зөрчсөн асуудал байна гэсэн зүйл яригдаж байгаад түрүүчийн хуулиуд өөрчлөлт орсон учраас ийм заалтыг оруулж байгаа юм. Энэ саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт.

11 гишүүнээс 8 нь дэмжиж, 72.7 хувиар энэ саналыг дэмжлээ.

Мөн 3 дугаар зүйлийн “32.10” дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулъя гэж санал оруулж байна.

32.10.Баг, хорооны иргэдийн Нийтийн анхдугаар хуралдаанаас хуралдаан даргалагчийг 2 жилийн хугацаагаар сонгоно. Хуралдаан даргалагч нь хуралдааныг удирдан явуулах, хуралдааны шийдвэрийг албажуулан гарын үсэг зурах, дараагийн хуралдааны зохион байгуулалтын бэлтгэлийг хангах үүрэгтэй. Хуралдааны даргад баг, хорооны Засаг даргын албан тушаалын үндсэн цалингийн 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгоно, олгож болно.” гэсэн санал оруулж байгаа.

Орж ирэхдээ 4 жилээр байсан бас ротацтай юу яая гэдэг утгаар 2 жил болгоод, урамшуулал олгоно гэж байсныг одоо хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуулийн заалттай уялдуулаад болно гэж өөрчилж оруулж байгаа. Саналыг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт.

12 гишүүн оролцож, 8 нь дэмжиж, 66.7 хувиар энэ санал дэмжигдлээ.

3 дугаар зүйлийг хэлэлцээж дууслаа.

4 дүгээр зүйл дээр асуулт, санал байхгүй.

Үүгээр Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцээж дууслаа.

Санал, дүгнэлтийг Ганболд гишүүн Байнгын хорооны хуралдаанд танилцуулчих.

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа. Дараагийн асуудалдаа оръё.

09.56 цаг

Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулна.

Энэ хуулийг Адъяа нарын 4 гишүүн өргөн мэдүүлсэн. Төслийг зүйл бүрээр нь хэлэлцэх ёстой.

Төслийн 1 дүгээр зүйл дээр хууль санаачлагч нартай санал солилцоод дараах зарчмын зөрүүтэй саналыг оруулж байна.

1 дүгээр зүйл. Үндэсний их баяр наадмын тухай хууль доор дурдсан агуулгатай 10.20 дахь хэсэг нэмсүгэй:

10.20. Энэ хуулийн 10.19-д заасан жороо морины уралдаанд морио уяж, уралдуулсан уяачийн амжилт нь энэ хуулийн 10.4, 10.5, 10.6-д заасан болзлыг

хангасан бол уяачид мөн хэсэгт заасан цол олгоно. Саяын уншсан томъёоллыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

12 гишүүн оролцож, 10 нь дэмжиж, 83.3 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 2 дугаар зүйл дээр санал, асуулт байхгүй.

Төслийн 3 дугаар зүйл дээр доор дурдсанаар өөрчлөн найруулах санал оруулж байна.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Энхболд. Дагаж мөрдөх хугацаатай холбогдсон заалт. Саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя. Санал хураалт.

12 гишүүнээс 9 нь дэмжиж, 75 хувиар уг санал дэмжигдэж байна.

Үүгээр Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг зүйл бүрээр нь хэлэлцээж дууслаа.

Уг хуулийн анхны хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

Санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Жаргалмаа гишүүн танилцуулна.

Үүгээр Төрийн байгуулалтын байнгын хорооны өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх, болохгүй зарчмын зөрүүтэй санал гарчихсан юм. Тийм. Уг нь хууль санаачлагчийн зүгээс тийм юм ирсэн. Тэгэхдээ 2 ч зарчмын зөрүүтэй санал гарчихсан учраас анхны хэлэлцүүлгээр баталж болохгүй байгаа юм.

Төрийн байгуулалтын байнгын хороо өнөөдрийн хэлэлцэх асуудлаа дууслаа. Хуралдаан хаасныг мэдэгдье. Гишүүддээ баярлалаа.

Дараагийн долоо хоногт 2 удаа
хуралдана. Гишүүдийгээ идэвхтэй
оролцохыг урьж байна.

09.59 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР